



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 5/07

Ховд

Г Н.Ганбатыг ажилд томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.11 дүгээр зүйлийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын 2021 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 05/870 тоот албан бичгээр хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирсэн Намжилын Ганбатыг “Шим-Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын даргын албан тушаалд 2021 оны 01 дүгээр сарын 28-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Н.Ганбатыг Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолын “Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”-ний 9 дүгээр хавсралтын дагуу TY11-3 дахь шатлал болох 932617 төгрөг /Есөн зуун гучин хоёр мянга зургаан зуун арван долоон/-өөр цалинжуулахыг “Шим-Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын нягтлан бодогч /Ч.Даваадорж/-д зөвшөөрсүгэй.

3. Н.Ганбатын ажлыг хүлээлцүүлэх ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдол бүрт тайлбар, мэдүүлэг гаргаж ажиллахыг Н.Ганбатад даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ



Zax B/07 Ch  
02 0423

Аймгийн Засаг даргын 2021 оны  
01 дүгээр сарын 28-ны өдрийн  
Б/07 дугаар захирамжийн хавсралт

АЖИЛ ХҮЛЭЭЛЦҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН

Ахлагч: Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө  
оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн  
хэлтсийн дарга

Гишүүд: Б.Түмэндэмбэрэл -Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого,  
төлөвлөлтийн хэлтсийн ахлах  
мэргэжилтэн

М.Нансалмаа -“Шим-Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрын өрөнхий  
инженер

Ч.Даваадорж -“Шим-Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрын нягтлан  
бодогч

Нарийн бичгийн

дарга: А.Эрдэнэсүрэн -“Шим-Ус” орон нутгийн өмчит, аж ахуйн  
тооцоот үйлдвэрийн газрын нярав

-оОо-